| Бараа материалын орлого, зарлагын үзүүлэлт | Дүн |
|---|---|
| **2023 оны эхний үлдэгдэл** | **723,437.3** |
| ***Нэмэгдсэн*** | **1,924,177.2** |
| Худалдан авсан | 1,781,434.1 |
| Шилжүүлэн авсан | 142,743.1 |
| ***Хасагдсан*** | **1.433.262.6** |
| Худалдсан, зарцуулсан | 312,664.0 |
| Шилжүүлсэн | 1,120,598.6 |
| **2023 оны эцсийн үлдэгдэл** | **1,214,351.8** |

*Эх сурвалж: Баянхонгор сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 1,924,177.2 мянган төгрөгийн бараа материалын 1,781,434.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 142,743.1 мянган төгрөгийн шилжүүлсэн авсан хөрөнгөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 135,113.3 мянга, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 7,629.7 мянган төгрөгийн хөрөнгийг  ЗДТГ-т шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Мөн тайлант онд нийт 312,664.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т нийт 511,441.6 мянга, Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-д 90,000.0 мянга, Чандмань-Баянхонгор ХК-д 124,326.2 мянга, сумын ЗДТГ-т 344830.8 мянга, Цэвэр хот ОНӨААТҮГ-т 15,000.0 мянга, сургууль, цэцэрлэгүүд болон бусад байгууллагуудад 35,000.0 мянга, нийт 1,120,598.6 төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,595,077.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 779,143.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| **БИЕТ ХӨРӨНГӨ** | **2,725,107.1** | **3,504,250.3** | **779,143.3** | **97.5** |
| Барилга байгууламж, орон сууц | 1,866,032.0 | 2,085,515.9 | 219,483.9 | 58.0 |
| Тээврийн хэрэгсэл | 208,135.2 | 242,196.2 | 34,061.0 | 6.7 |
| Машин тоног төхөөрөмж | 359,907.8 | 417,171.7 | 57,263.9 | 11.6 |
| Тавилга эд хогшил | 273,658.8 | 294,058.3 | 20,399.5 | 8.2 |
| Номын фонд | 473.3 | 1,081.4 | 608.1 | 0.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 16,900.0 | 464,226.8 | 447,326.8 | 12.9 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | **90,827.0** | **90,827.0** | **-** | **2.5** |
| Программ хангамж | 4,375.0 | 4,375.0 | - | 0.1 |
| Бусад биет бус хөрөнгө | 86,452.0 | 86,452.0 | - | 2.4 |
| | **2,815,934.1** | **3,595,077.3** | **779,143.3** | **100.0** |

*Эх сурвалж: Баянхонгор  сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,595,077.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 779,143.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 447,326.8  мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 219,483.9 мянган төгрөгийн барилга байгууламжийг сумын ЗДТГ болон Шаргалжуут тосгоны захирагчийн ажлын албанд шилжүүлэн авч бүртгэсэн нь нь голлох нөлөө үзүүлж байна

*Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* */мянган төгрөгөөр/*

| Байгууллагуудын нэрс | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 100,383.5 | 97,233.3 | (3,150.2) | 2.7 |
| Засаг даргын тамгын газар | 2,378,500.4 | 3,080,799.3 | 702,298.9 | 85.7 |
| Шаргалжуут тосгоны ЗАА | 337,050.1 | 417,044.8 | 79,994.7 | 11.6 |
| **Дүн** | **2,815,934.0** | **3,595,077.4** | **779,143.4** | **100.0** |

*Эх сурвалж: Баянхонгор  сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Тайлант онд нэмэгдсэн 845,299.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн 92.8 хувь буюу 784,367.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Үүнд: Сумын ЗДТГ-т сумын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 189,483.9 мянган төгрөгийн барилга байгууламж, 20,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 426,669.6 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 30,625.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, сумын ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 7,510.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хуваарилсан.

Шаргалжуут тосгоны захирагчийн ажлын албанд сумын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 50,657.2 мянган төгрөгийн барилга байгууламж, бусад эх үүсвэрээс 58,571.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, сумын ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 850.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлсэн бүртгэсэн бөгөөд нийт 57,796.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 8360.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө* */мянган төгрөгөөр/*

| | |
|---|---|
| **2023 оны эхний үлдэгдэл** | **2,815,934.1** |
| ***Нэмэгдсэн*** | **845,299.7** |
| Худалдан авсан | 60,932.5 |
| Бусад | 784,367.2 |
| ***Хасагдсан*** | **66,156.4** |
| Акталсан | 57,796.4 |
| Шилжүүлсэн | 8,360.0 |
| **2023 оны эцсийн үлдэгдэл** | **3,595,077.3** |

*Эх сурвалж: Баянхонгор сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 37,068.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,410.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл / мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **38,479.2** | **37,068.9** | **(1,410.3)** | **100.0** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 248.4 | 388.2 | 139.8 | 1.0 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 9.5 | 9.5 | - | 0.0 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 38,221.3 | 36,498.4 | (1,722.9) | 98.5 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 172.8 | 172.8 | 0.5 |

*Эх сурвалж: Баянхонгор сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Богино хугацаат өр төлбөр нь 37,068.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд үүнд сургууль, цэцэрлэгийн тогтмол зардлын өглөг 10,443.4 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн байгууллагад өгөх өглөг 25,935.0 мянга, хоршоо хөгжүүлэх сангийн ХХОАТ-ын өглөг 120 мянга, ИТХ-ын ажилчидтай холбоотой өглөг 388.2 мянга, бараа үйлчилгээний өглөг 9.5 мянга, ЗДТГ-ын хувь хүнд өгөх өглөг 172.8 мянган төгрөг байна.

*Хүснэгт 11. Өглөгийн дансны үлдэгдэл* */мянган төгрөгөөр/*

| Байгууллагуудын нэр | Өглөгийн эхний үлдэгдэл | Өглөгийн эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 9.5 | 397.7 | 388.2 | 1.1 |
| Засаг даргын тамгын газар | 248.4 | 172.8 | (75.6) | 0.5 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 38,221.3 | 25,935.0 | (12,286.3) | 70.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Сургууль, цэцэрлэг | | 10,443.4 | 10,443.4 | 28.2 |
| Хоршоо хөгжүүлэх сан | | 120.0 | 120.0 | 0.3 |
| **ТШЗ-ийн байгууллагын ДҮН** | **38,479.2** | **37,068.9** | **(1,410.3)** | **100.0** |

*Эх сурвалж: Баянхонгор сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,361,526.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,045,665.4 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо* */мянган төгрөгөөр/*

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 956,190.3 | 956,190.3 | - |
| Өмч: - төрийн | 956,190.3 | 956,190.3 | - |
| **Хуримтлагдсан үр дүн** | 3,584,785.3 | 4,625,644.1 | 1,040,858.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 366,795.9 | 366,795.9 | - |
| | **4,907,771.5** | **5,948,630.4** | **1,040,858.9** |

*Эх сурвалж: Баянхонгор сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үлдэгдэл 5,948,630.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,040,858.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр өссөнтэй холбоотой байна.

### 3.5.11 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2022.12.16-ний өдрийн хуралдаанаар 8/49 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 8,978,738.1 мянга, хүү торгуулийн орлогыг 59,000 мянга, ОНХС-ийн шилжүүлгийг 906,555.2 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 216,740.0 мянга, урд оны үлдэгдлийг 714,331.9 мянга нийт 10,875,365.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.08.21-ны өдрийн 11/68 дугаар тодотгосон тогтоолоор татварын орлогыг 9,106,822.0 мянга, татварын бус орлогыг 138,846.0 мянга, ОНХС-ийн шилжүүлгийг 1,109,054.9 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 216,740.0 мянга, урд оны үлдэгдлийг 1,404,331.9 мянга нийт 11,975,794.8 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 12. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл* */мянган төгрөгөөр/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **1.Татварын орлого** | **9,106,822.0** | **10,032,471.5** | **1,038,626.6** | **110.2** |
| 1.1. ЦХТАО /суутган-1/ | 5,927,230.0 | 6,971,825.0 | 1,044,595.0 | 117.6 |
| 1.2.ИОТХ | 504,000.0 | 423,614.2 | (80,385.8) | 84.1 |
| 1.3. Хадгаламжийн хүүгийн орлого | 585,600.0 | 598,302.0 | 12,702.0 | 102.2 |
| 1.4. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар | 343,000.0 | 304,603.3 | (38,396.7) | 88.8 |
| 1.5.Бууны татвар | 9,570.0 | 10,961.0 | 1,391.0 | 114.5 |
| 1.6.Улсын тэмдэгтийн хураамж | 42,000.0 | 40,109.4 | (1,890.6) | 95.5 |
| 1.7. Газрын төлбөр | 150,000.0 | 138,909.7 | (11,090.3) | 92.6 |
| 1.8.Ан агнуурын нөөц ашигласны төлбөр | 150,000.0 | 125,280.0 | (24,720.0) | 83.5 |
| 1.9. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 620,200.0 | 760,325.4 | 140,125.4 | 122.6 |
| 1.10. ТТАМАТөлбөр | 5,000.0 | | (5,000.0) | - |
| 1.11. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 554,400.0 | 546,757.0 | (7,643.0) | 98.6 |
| 1.12. Малын тоо толгойн албан татвар | 37,822.0 | 46,761.6 | 8,939.6 | 123.6 |
| 1.13 Газрын дуудлага худалдаа | 168,000.0 | 54,931.3 | (113,068.7) | 32.7 |
| 1.14 Ус рашаан ашигласны төлбөр | 10,000.0 | 10,091.6 | 91.6 | 100.9 |
| **2.Татварын бус орлого** | **138,846.0** | **177,576.1** | **7,120.0** | **127.9** |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 138,846.0 | 177,576.1 | 7,120.0 | 127.9 |
| **Нийт дүн** | **9,245,668.0** | **10,210,047.6** | **1,045,746.6** | **110.4** |

*Эх сурвалж: Баянхонгор сумын ИТХ-ын тогтоол*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 1,045,746.6 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн ч орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлогоос татвар төлбөр хураамжийн орлого 80,385.8 мянга, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 38,396.5 мянга, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,890.6 мянга, газрын төлбөр 11,090.6 мянга, ан агнуур 24,720.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 113,068.7 мянга, үл хөдлөх эд хөрөнгийн татвар 7,643.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал 5,000.0 мянга, нийт 282,195.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

### 3.5.12 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 7 хөтөлбөрт зориулан 10,147,980.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 9,615,395.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 8,451,438.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 1,163,957.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 3 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022.12.16-ний өдрийн 8/49 дүгээр тогтоолоор нийт 8,844,539.2 мянган төгрөгийг баталсан байна.

*Хүснэгт 13. Төсвийн төлөвлөлт* *\/мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 365,727.0 | 351,145.8 | (14,581.2) |
| Засаг даргын Тамгын газар | 1,274,857.1 | 2,314,937.9 | 1,040,080.8 |
| Баянхонгор сумын сургуулиуд | | 3,547,196.9 | 3,547,196.9 |
| Баянхонгор сумын цэцэрлэгүүд | | 1,213,841.6 | 1,213,841.6 |
| Эрүүл мэндийн төв | | 41,835.5 | 41,835.5 |
| Шаргалжуут тосгоны ЗАА | 57,739.6 | 58,582.4 | 842.8 |
| СХСан | | 268,790.0 | 268,790.0 |
| ОНХСан | | 1,048,209.1 | 1,048,209.1 |
| Нийт дүн | 1,698,323.7 | 8,844,539.2 | 7,146,215.5 |

*Эх сурвалж: Баянхонгор сумын ИТХ-ын тогтоол*

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2022.12.16-ны өдрийн 8/49 дүгээр тогтоолоор анх 8,844,539.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.08.21-ний өдрийн 11/68 дугаар тогтоолоор 10,147,980.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 9,207,846 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоор, 1,109,054.9 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас

олгох санхүүжилтээс, 216,740.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 1,404,331.9 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 10,147,980.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 178,393.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 14. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* */мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Төвлөрүүлэлт |
|---|---|---|---|---|---|
| Засаг даргын Тамгын газар | 3,058,109.40 | 2,980,127.90 | 77,981.50 | 97.5 | 77,981.50 |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 521,553.40 | 496,860.68 | 24,692.72 | 95.3 | 24,692.72 |
| Шаргалжуут тосгоны ЗАА | 80,747.70 | 78,066.60 | 2,681.10 | 96.7 | 2,681.10 |
| Хоршоо хөгжүүлэх сан | 268,790.00 | 1,400.00 | 267,390.00 | 0.5 | - |
| Сургууль | 3,676,649.70 | 3,646,307.40 | 30,342.30 | 99.2 | 30,292.30 |
| Цэцэрлэг | 1,249,586.40 | 1,210,550.40 | 39,036.00 | 96.9 | 39,036.00 |
| Эрүүл мэндийн төв | 41,835.50 | 38,125.90 | 3,709.60 | 91.1 | 3,709.60 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 1,250,708.80 | 1,163,957.20 | 86,751.60 | 93.1 | - |
| **Нийт дүн** | **10,147,980.90** | **9,615,396.08** | **532,584.82** | **94.8** | **178,393.22** |

*Эх сурвалж: Баянхонгор сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь ЗДТГ-ын төсвийг 77,981.5 мянга, ИТХ-ын төсвийг 24,692.7 мянга, Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 30,342.3 мянга, сургуулийн өмнөх боловсролын зардал 39,036.0 мянга, Эрүүл мэндийн төвийн төсвийг 3,709.6 мянга, Шаргалжуут тосгоны захирагчийн ажлын албаны төсвийг 2,681.0 мянган төгрөгөөр тус тус зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 124,014.2 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 29,408.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бараа үйлчилгээний зардалд 149,913.9 мянган төгрөгийг зарцуулж, 3,508.6 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | ЗДТГ | ИТХ | Нийт |
|---|---|---|---|
| **Нийт нэмэлт санхүүжилтийн орлого** | **150,107.5** | **3,315.0** | **153,422.5** |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 120,699.2 | 3,315.0 | 124,014.2 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,408.3 | | 29,408.3 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | **146,613.9** | **3,300.0** | **149,913.9** |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 146,613.9 | 3,300.0 | 149,913.9 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - | - |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | - | - |
| **ТӨВЛӨРҮҮЛСЭН** | **3,493.6** | **15.0** | **3,508.6** |

*Эх сурвалж: Баянхонгор сумын санхүүгийн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сумын засаг даргын нөөц санг 175,000.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 174,987.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагын 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 7 бүлэг, 16 зорилго, 149 зорилттойгоор төлөвлөж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд хэрэгжилтийг 86.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлжээ.

### 3.5.5 Аудитын гол асуудал

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 10,147,980.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 9,615,396.1 мянган төгрөгийг зарцуулж, 94.8 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 9,245,668.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 10,210,047.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 110.4 хувьтай биелүүлж, аймгийн төсөвт 1,827,813.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 3 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Баянхонгор сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

*Хүснэгт №16. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэсэн | | | Үүнээс | | | |
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Бие дааж дүгнэлт гаргасан | Түвэрт хамруулсан | Бүгд | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **ЗДТГ** | 1 | 1 | 1 | | 1 | | 1 | | |
| **ИТХурал** | 1 | 1 | 1 | | 1 | 1 | | | |
| **Шаргалжуут тосгоны ЗАА** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ОНХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **СХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **5** | **5** | **2** | **3** | **2** | | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Нийт илэрсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн 159,567.4 мянга, нийцлийн аудитын асуудалтай холбоотой 545,033.7 мянган төгрөгийн зөрчил илэрчээ. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн*

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Залруулга | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн зөрчил** | | | | | | | | | | |
| **ЗДТГ** | 12 | 147,272.3 | | | 4 | 17,632.8 | 8 | 129,639.5 | | |
| **Шаргалжуут ЗАА** | 1 | 1,608.3 | | | 1 | 1,608.3 | | | | |
| **ОНХС** | 3 | 10,686.8 | | | 3 | 10,686.8 | | | | |
| ***СТА зөрчлийн дүн*** | **16** | **159,567.4** | ***0*** | ***0*** | **8** | **29,927.9** | **8** | **129,639.5** | ***0*** | ***0*** |
| **СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | |
| **ОНХС** | 1 | 545,033.7 | | | | | 1 | 545,033.7 | | |
| ***Нийцлийн аудитын дүн*** | **1** | **545,033.7** | | | | | **1** | **545,033.7** | | |
| **Нийт дүн** | **17** | **704,601.1** | **0** | **0** | **8** | **29,927.9** | **9** | **674,673.2** | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

*Хүснэгт 18: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт*

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Харьяа төсвийн байгууллагуудын дүн** | | **704,601.1** | | | |
| **Засаг даргын тамгын газар** | | **147,272.3** | | | |
| **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** | | | | | |
| 1 | Тайлант хугацааны 11,12 дугаар сард 66 албан хаагчдаас суутгасан 3870.0 төгрөгийн хамтын санг цалин дээр нэмэгдэл хасахаар суутган тооцож Нийгмийн даатгалд дутуу мэдээлсэн байна. | 3,870.0 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 2 | Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 09 ний өдөр 111/ШШ2022/0006 дугаар шийдвэрийн дагуу Баянхонгор сумын Засаг даргын Б/25 тоот захирамжаар сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч байсан Б.Ишмаад ажилгүй байсан хугацааны цалинд 11530.1 мянган төгрөгийг олгосон. Энэ нь захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т" Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлж байна. | 11,530.1 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 3 | Тус газрын Тамгын газрын дарга нь нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас тушаалын хавсралтад нэр оруулж 100.0 мянган төгрөгийг авсан. | 100.0 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 4 | Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 65774.6 мянган төгрөгийг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагч, ажилтан нарт буцалтгүй тусламж үзүүлэхэд мөрдөх журам боловсруулан зарцуулсан. | **65,744.6** | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 5 | Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад 14181.0 мянган төгрөгөөр гамшгаас | **14,810.0** | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | хамгаалах, байгаль орчны албан хаагчдад нормын хувцас хийлгэсэн. | | | | |
| 6 | Тайлант хугацаанд багийн Засаг дарга Г.Нямдаваа, мэргэжилтэн Г.Гүндалай нарт 4, 12 дугаар сарууудад ажилласан хоногт ноогдох 299.6 мянган цалин бодож олгоогүй. | **299.6** | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 7 | Тайлант хугацаанд гүйлгээгээр 30,714.2 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй байхад сумын Төрийн сангийн мэргэжилтэн, албаны дарга нар гүйлгээг баталж зарцуулсан байна. | **30,714.2** | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 8 | БТОЗ ХХК-д цэрэг татлага хулдаасан хэвлэлийн зардал 144.0 мянган төгрөгийг 2 удаа давхардуулан шилжүүлсэн. | **144.0** | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 9 | Тамгын газрын даргын 2023 оны 03 сарын 01 ний Б/29 тоот тушаалаар жирэмсний, амаржсаны амралт авсан Ц.Нансалмаагийн нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд 4,5,6 дугаар сарууды мэдээлээгүй, Тамгын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр үүргэт ажлаасаа чөлөөлөгдсөн Х.Нямсүрэнгийн 7,8,9 дүгээр сарууд нийгмийн даатгалын шимтгэлийг илүү мэдээлсэн. | **3,300.0** | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 10 | Баянхонгор сумын 2023 онд ногоон байгууламж нэмэгдүүлсэн ойн зурвасуудад цас овоолж модны нүх цар дүүргэх овоолох ажлын хийж гүйцэтгэх 14 тоот гэрээг 2023 оны 12 дугаар сарын 15 өдөр байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй | **12,600.0** | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 11 | Тус байгууллагын биет бус хөрөнгийн бүртгэлд тусгасан газар нь Газар хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанаас 6409009222, 6409010524 нэгж талбарын дугаар бүхий талбай бүртгэлд тусгагдаагүй 5200 м2-аар дутуу зөрүүтэй байна. | **0** | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| 12 | Тайлант хугацаанд ХХОАТ-ын зардалд 4788.8 мянган төгрөгийг илүү төлсөн, Татварын хэлтэстэй тооцоо нийлээгүй санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй. | **4,788.8** | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| | Дүн | **147,272.3** | | | |
| **Шаргалжуут тосгоны захирагчийн ажлын алба** | | **1,608.3** | | | |
| **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** | | | | | |
| 1 | Ажилчдын 7.8 дугаар сарын нийгмийн даатгалын мэдээг цалингийн цэстээр цалин хөлсний дүнгээс зөрүүтэй мэдээлсэн. | 1,608.3 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Г.Хүрэлсүх, Э.Батчимэг |
| | Дүн | **1,608.3** | | | |
| **Орон нутгийн хөгжлийн сан** | | **555,720.5** | | | |
| **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** | | **10,686.8** | | | |
| **1** | Баянхонгор аймгийн Замын сангаас 2023.10.13-д "Аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх" ажилд 80,000.0 мянган төгрөгийн эрх шилжин ирж 78,400.0 мянган төгрөг шилжүүлж тендерийн хэмнэлт 1,600.0 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлээгүй байна | **1,600.0** | Төлбөрийн акт | Засаг дарга, нягтлан бодогч | Г.Энхбаяр, А.Цагаандолгор |
| **2** | Баянхонгор аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 13 төсөл арга хэмжээний 577,150.0 мянган төгрөг шилжин ирж гүйцэтгэлээр 568,746.2 мянган төгрөгийн шилжүүлж тендерийн хэмнэлт 8406.8 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлээгүй байна. | **8,406.8** | Төлбөрийн акт | Засаг дарга, нягтлан бодогч | Г.Энхбаяр, А.Цагаандолгор |
| **3** | Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын А/240 дүгээр захирамжаар "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрны урамшуулал"-д 130,000.0 мянган төгрөг шилжин ирж 130,680.0 мянган төгрөгийг шилжүүлж 680.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна. | **680.0** | Төлбөрийн акт | Засаг дарга, нягтлан бодогч | Г.Энхбаяр, А.Цагаандолгор |
| | **Дүн** | **10,686.8** | | | |
| **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | |
| 1 | Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлд 1,114,733.8 мянган төгрөгийн 44 гэрээ байршуулахаас 545,033.7 мянган төгрөгийн 21 гэрээг байршуулаагүй байна. | **545,033.7** | Албан шаардлага өгсөн. | Засаг дарга, нягтлан бодогч | Г.Энхбаяр, А.Цагаандолгор |
| | Дүн | **545,033.7** | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

### 3.5.6 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 7 хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 10,147,980.9 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 9,615,395.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэлийн тайлан* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,147,980.9** | **9,615,395.9** | **532,585.0** | **94.8** |
| **70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага** | **521,553.4** | **496,860.6** | **24,692.8** | **95.3** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 425,766.6 | 407,164.9 | 18,601.7 | 95.6 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 600.0 | 600.0 | - | 100.0 |
| 82201 ГХУСАХЗ | 80,000.0 | 74,791.0 | 5,209.0 | 93.5 |
| 80825 Багийн ИНХ-ын дарны урамшуулал | 15,186.8 | 14,304.7 | 882.1 | 94.2 |
| **70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага** | **3,138,857.1** | **3,058,194.4** | **80,662.7** | **97.4** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,183,556.3 | 1,119,341.2 | 64,215.1 | 94.6 |
| 80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | 143,000.0 | 139,841.2 | 3,158.8 | 97.8 |
| 80106 Баг, хорооны ҮАЗардал | 515,229.6 | 505,119.7 | 10,109.9 | 98.0 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 70,000.0 | 69,714.7 | 285.3 | 99.6 |
| 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 175,000.0 | 174,987.3 | 12.7 | 100.0 |
| 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 273,271.2 | 270,390.3 | 2,880.9 | 98.9 |
| 82212 Хур хог хаягдал, орчны бохирдл | 778,800.0 | 778,800.0 | - | 100.0 |
| **70503 Орон нутгийн зорилтот ХОруулал** | **1,250,708.8** | **1,163,957.2** | **86,751.6** | **93.1** |
| 80904 Нийгмийн зориулалттай барилга | 103,831.9 | 45,332.7 | 58,499.2 | 43.7 |
| 83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох | 947,346.1 | 919,394.4 | 27,951.7 | 97.0 |
| 83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар | 37,822.0 | 37,521.3 | 300.7 | 99.2 |
| 83406 ОНХС - Бусад | 161,708.8 | 161,708.8 | - | 100.0 |
| **71602 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ** | **41,835.5** | **38,125.9** | **3,709.6** | **91.1** |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 41,835.5 | 38,125.9 | 3,709.6 | 91.1 |
| **71801 Сургуулийн өмнөх боловсрол** | **1,249,586.4** | **1,210,550.4** | **39,036.0** | **96.9** |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 1,249,586.4 | 1,210,550.4 | 39,036.0 | 96.9 |
| **71802 Ерөнхий боловсрол** | **3,676,649.7** | **3,646,307.4** | **30,342.3** | **99.2** |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 3,676,649.7 | 3,646,307.4 | 30,342.3 | 99.2 |
| **72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих** | **268,790.0** | **1,400.0** | **267,390.0** | **0.5** |
| 82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих | 268,790.0 | 1,400.0 | 267,390.0 | 0.5 |

*Эх сурвалж: Баянхонгор сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт  2023 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн 1/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 9,110,550.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 91,105.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 63,773.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянхонгор  сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сумын хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөөнд захиргааны зориулалттай шинээр байшин барилга тусгаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно” гэсэн заалттай нийцэж байна.

### 4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn  цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 155 мэдээллээс тухай бүр мэдээлсэн байдлыг шалгахад тус сумын Орон нутгийн хөгжлийн сан нь хуулийн 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлд 1,114,733.8 мянган төгрөгийн 44 гэрээ байршуулахаас 545,033.7 мянган төгрөгийн 21 гэрээг байршуулаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах албан шаардлагыг хүргүүлсэн.

## 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.7.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаан завсрын аудит хийгээгүй болно.

### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 765,107.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж, зөрчлийг арилгах 10,666.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 1/301 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 16. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж* */ мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 765,107.5 | 3 | 765,107.5 | 0 | 0 | 100 |
| Албан шаардлага | 1 | 10,666.5 | 1 | 10,666.5 | 0 | 0 | 100 |
| ***Нийт*** | **4** | **775,774.0** | **4** | **775,774.0** | **0** | **0** | **100** |

*Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт*

## 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 282,195.2 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрсэнд алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, зөрчлийг арилгах 282,195.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

## 5.1 Албан шаардлага

*5.1.1 Илрүүлэлт:* Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос иргэнийн орлогоос татвар төлбөр хураамжийн орлогоос 80,385.8 мянга, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 38,396.5 мянга, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,890.6 мянга, газрын төлбөр 11,090.6 мянга, ан агнуур 24,720.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 113,068.7 мянга, үл хөдлөх эд хөрөнгийн татвар 7,643.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал 5,000.0 мянга, нийт 282,195.2 мянган төгрөгөөр тасарсан байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8[2], Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3[3] дахь заалт, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөж байх, төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Баянхонгор сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 704,601.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 29,927.9 мянган төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 673,674.2 мянган төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.10[4] дахь заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Харьяа төсөвт байгууллагуудын санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг дээшлүүлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Баянхонгор сумын төсөвт төвлөрөх орон нутгийн орлогод Шаргалжуут тосгоны рашааны бүсээс хог хаягдлын хураамжийг хуулийн дагуу төвлөрүүлж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Баянхонгор сумын төсөвт Шаргалжуут рашаан сувиллын рашааны бүсээс хог хаягдлын хураамжийг төвлөрүүлж, орон нутгийг орлогыг нэмэгдүүлэх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

[2] Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ
[3] жинхэнэ хэрэгжилтийн
[4] өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Баянхонгор сумын Засаг дарга | 2 | 282,195.2 | | | 1 | 282,195.2 | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **2** | **282,195.2** | | | **1** | **282,195.2** | **1** | **0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос иргэнийн орлогоос татвар төлбөр хураамжийн орлогоос 80,385.8 мянга, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 38,396.5 мянга, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,890.6 мянга, газрын төлбөр 11,090.6 мянга, ан агнуур 24,720.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 113,068.7 мянга, үл хөдлөх эд хөрөнгийн татвар 7,643.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал 5,000.0 мянга, нийт 282,195.2 мянган төгрөгөөр тасарсан байна. | 1 | 282,195.2 | | | 1 | 282,195.2 | | |
| Баянхонгор сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 704,601.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 29,927.9 мянган төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 673,674.2 мянган төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлсэн байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| ***ДҮН*** | **2** | **282,195.2** | | | **1** | **282,195.2** | **1** | **0** |